

ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2021.01.22

Даланзадгад

Өмнөговь аймгийн 2021 оны 01 дүгээр сарын мэдээ

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл

2021.01 САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГА

1. Долоо хоног бүрийн Ням гаригийг “Хөгжлийн цаг” болгож иргэдийн саналыг сонсох, мэдээлэл гомдлыг хүлээн авах, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах арга хэмжээг зохион байгуулж эхлээд байна. Энэ оны анхны “Хөгжлийн цаг” уулзалтыг 01 сарын 10, 17-ны Ням гаргуудад зохион байгуулж, нийт 56 иргэн оролцож санал хүсэлтээ илэрхийллээ. Уулзалтын хүрээнд иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг судлан хуулийн хугацаанд буюу 30 хоногийн дотор холбогдох хэлтэс нэгж, төрийн байгууллагуудаас шуурхай шийдвэрлэн, хариуг угтсаар болон биеэр өгч ажиллаж байна.

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 109 дэх заалтад “Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 сарын 12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж эхэллээ. Уг журамд тусгасан болзол шаардлагыг хангасан төрийн албан хаагчид орон сууцтай болоход нь тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх, мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэхэд нь сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, эмчилгээний зардал, ажиллах орчин нөхцөлөө сайжруулахад нь тус тус дэмжлэг үзүүлэх боломж нөхцөл бүрдлээ. Уг журамд заасан дэмжлэгт хамрагдах хүсэлтэй төрийн албан хаагчид болзол журмыг бүрэн хангаж байгаа гэж үзэж байгаа тохиолдолд өөрийн хүсэлт, бусад холбогдох баримт бичгийг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлнэ.

3. Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудаар Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, тайлагнах, үнэлэх журмууд тус тус батлагдсан. Мөн эдгээр журмуудтай уялдан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар дээрх төлөвлөлтийн маягтуудыг баталсан байгаа. Иймд дээрх журам, маягтын дагуу аймгийн төрийн байгууллага, албан хаагчид 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарч

ажиллах шаардлага бий болж байна. Журмыг хэрэгжүүлэх, байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, нэгжээс арга зүйн заавар, зөвлөмж өгөх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

4. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, улсын болон аймгийн хэмжээнд өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Баяннуур хотын засгийн ордонтой урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар харилцан шуурхай мэдээлэл солилцох, нүүрс тээвэрлэлт, хилийн боомтын үйл ажиллагааг сайжруулахад баримтлах зарчим, хамтран ажиллах чиглэлээр уулзалтыг цахимаар зохион байгууллаа.

5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Бадраа, аймгийн Засаг даргын орлогч Н.Энхбат нараар ахлуулсан ажлын хэсэг Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй сумдын удирдлагуудтай уулзаж, цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, өвөлжилтийн нөхцөл байдалтай холбоотойгоор мэдээлэл солилцож, холбогдох үүрэг чиглэл өгч ажиллалаа. Түүнчлэн Ноён, Гурвантэс сумдад үйл ажиллагаа явуулж буй уул, уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар санал бодол солилцсон байна.

6. Аймгийн Засаг даргаар ахлуулсан 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Цогт-Овоо, Цогтцэций, Ханбогд сум, Цагаан хад суурьшлын бүсэд 2021 оны 01 сарын 14, 15-ны өдрүүдэд ажиллаж байна. Өвөлжилтийн нөхцөл байдал, Цогт-Овоо сумын постын үйл ажиллагаа, Цагаан хад суурьшлын бүсийг тог цахилгаантай болгох зэрэг томоохон асуудлуудад тулгуурлан холбогдох мэдээлэл судалгааг авч, үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

1.Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн чиглэлээр

Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс тэжээл нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 200 тонн өвс нийлүүлэх ажлыг “Домогт хар уул” ХХК-тай, 98 тн тэжээл нийлүүлэх ажлыг “Тэнгисийн шүр” ХХтай гэрээ байгуулан гүйцэтгүүлээ. Гүйцэтгэгч компаниуд гэрээт ажлаа хугацаанд нь гүйцэтгэн хүлээлгэн өгөөд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоолоор цаг хүндрэлтэй байгаа аймгуудад Улсны нөөцийн салбараас сумдад өвсний үнийг 100 хувь, тэжээлийн үнийг 50 хувь хөнгөөл малчдад олгохоор шийдвэрлэсний дагуу манай аймагт хуваарилагдсан 300 тонн өвсийг сумдад малчин өрхийн тоонд

харицуулан хуваарилж, сумдад нэгдсэн зохион байгуулалттайгаар олгож байна. Мөн Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн хивэг, хорголжин тэжээлийг нэн хүндрэлтэй өвөлжиж байгаа сумдад хуваарилав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай 2021 онд хамтран ажиллах гэрээнд “Өмнөговь аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөө”-нд тусгагдан, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/6 дугаар тогтоолоор батлагдаж, орон нутгийн төсвөөс санхүүжигдэн хэрэгжихээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээнүүд болон бусад орон нутгийн хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийн саналыг хүргүүлээ.

“Өвөлжилт хүндэрч байгаа аймгуудын малчин өрхөд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах түр журам”-ын дагуу аймгийн Засаг даргын захирамжаар “Зудын хүндрэлийг даван туулах, малчин өрхөд тэжээл олгох ажлыг зохион байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэж ажиллах шуурхай бүлэг”, “Тэжээлийн агуулахын бэлэн байдлыг хангах, тээвэрлэгдэн ирсэн малын тэжээлийг хүлээн авах, сумдад хуваарилан тээвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллах ажлын хэсэг”-ийг тус тус томилон бэлтгэл ажлыг ханган ажиллаж, Өмнөговь аймгийн цаг хүндэрсэн 10 сумын 4017 малчин өрхийн судалгааг гарган Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгждэг Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл-д тус тус хүргүүлээ.

Сумдаас "Аймгийн аварга малчин", "Аймгийн аварга тариаланч"-д тодорхойлсон иргэдийн материалыг хүлээн авч байна. Одоогийн байдлаар 14 сумын 41 материал ирээд байна.

2. Уул уурхай, эрчим хүчний чиглэлээр

1. 2021.01.01-01.20-ыг хүртэлх хугацаанд нийт 3 захирамжийн төсөл бэлдэж албажуулсан, цаг үеийн холбогдолтой 15 албан бичиг төлөвлөн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн албан байгууллага, ААНБ-аас ирсэн 7 албан бичгийг шийдвэрлэж, холбогдох газарт хариу өгч хаасан байна.

2. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргав. Үүнд:

- “Алт-2” үндэсний хөтөлбөр
- Төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт
- Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

3. Уул уурхайн компаниудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулахтай холбогдуулан аймгийн ажлын хэсэг хуралдаж, гишүүдэд үүрэг чиглэл өгөх, нэгдсэн төлөвлөгөө болон Өмнөговь аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

3.Зам тээвэр барилга хот байгуулалтын чиглэлээр

1.Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-д 1 дүгээр сарын захирамжийг гарган СТСХ-т хүргүүлсэн. Мөн Зөнгийн түшээ ХХК-ийн нөхөн олговрыг тус зардлаас шийдвэрлэн, захирамжийг СТСХ-т хүргүүлсэн.

2.Барилгын тухай хууль, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авч 15 аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтийн дагуу улсын комисс ажиллах захирамжийг гарган ГХБХБГ-т хүргүүлэв.

3. Холбогдох журмын дагуу барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисст захиалагчийн төлөөллийг хэрэгжүүлэн ажиллаж, Номгон сумын цэвэр бохир усны шугам сүлжээ, Хайдро дизайн инноваци ХХК-ийн зохиогчийн хяналтын тайлан, барилга, байгууламжийн гүйцэтгэлийг шалган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

4.Ажил гүйцэтгэх гэрээ байгуулах чиглэлээр 1 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу ажил гүйцэтгэх гэрээний хугацааг сунгах ажлыг зохион байгуулав.

5.Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцыг буулган, шинээр барилгажуулах төслийн хүрээнд баригдаж буй 9 дүгээр орон сууцны төслийг хэрэгжүүлэгч “Гурван бухат” ХХК-д өгөх орон сууцны төлбөрөөс 2.58 кв.м буюу 3 663 600 төгрөгийг хасч тооцуулах тухай хүсэлт ирсний дагуу судлан үзэж, гүйцэтгэгч компанид дээрх асуудлыг уламжлах талаар албан бичгээр хариу хүргүүлж ажиллалаа.

6.“Хөгжлийн цаг” иргэдтэй уулзах уулзалтаар иргэдээс ирсэн санал хүсэлтийн дагуу 5-р орон сууцыг дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх гарын авлагыг өгч, шаардлагатай зөвлөмжүүдийг өгсөн.

7.Гүйцэтгэлийн баталгаа чөлөөлөх, санхүүжилт хүссэн, болон зохион байгуулалтын шинжтэй, тодорхойлолт хүргүүлэх гэх мэт 13 албан бичгийг холбогдох газарт хүргүүлж, улсын комисс ажиллуулах тухай 2 захирамжийг журмын дагуу гаргасан.

8.Дараах төсөл, хэрэгжилтийг тооцон гаргаж ажиллав.

1. ЗГҮАХ-ийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл
2. 3 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт
3. Захирамжийн хэрэгжилтийг программд бүрэн оруулж дуусгах
4. Төрөөс барилгын салбарт баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт
5. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт

4. Газрын харилцаа, хот байгуулалтын чиглэлээр 01 дүгээр сард хийгдсэн ажлууд

1. Ерөнхий архитекторын тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлэв.
2. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, цаашид шинэчлэн боловсруулах талаар санал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн цахим хуралд оролцов.
3. 2021 оны төсөвт туссан зураг төслийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж сонгон шалгаруулалтыг зарлах нөхцөлийг бүрдүүлж ажиллав.

5.Эдийн засаг, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, худалдаа үйлчилгээ, нийтийн ахуй үйлчилгээний чиглэлээр

1. ЗГХЭГ-аас “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хуулийн аймгийн Засаг даргын хэрэгжилтийг хангах заалтуудыг хэрэгжилтийг жил бүр тооцож ажиллах чиглэлийг өгсөн дагуу тус хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар тооцон гаргаж, хүргүүлж ажиллав.

2.Засгийн газрын 2020 оны 203 тогтоолын дагуу аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг саналыг нэгтгэн гаргаж, хүргүүлэв.

3. Тус хэлтсээс аймгийн ИТХ болон ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн боловсруулж саналыг ИТХТ-ийн ажлын албанд хүргүүлж, ажлын төлөвлөгөөнд хэлэлцүүлэн батлуулав.

4.Аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлсэн ажлуудын гүйцэтгэл тайланг аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллав.

5. Монгол Улсын Үндсэн хууль оруулсан нэмэлт өөрчлөлтөд нийцүүлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлагдсантай холбоотойгоор УИХ-ын даргын 2020.11.24-ний 51 дүгээр захирамжаар байгуулагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг”-т орон нутагт Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад авч хэрэгжүүлэх шаардлагатай саналыг УИХ-ын гишүүн С.Бямбацогтод хүргүүлэв.

6. Холбогдох хууль журмын дагуу мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны Үндсэн чиглэлийн жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт, аймгийг 2020 онд хөгжүүлэх 2021 оны жилийн төлөвлөгөө, аймгийн хэмжээнд 2021 онд улсын төсвийн болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлуудын мэдээлэл, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх ажлууд, аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл зэргийг олон нийтэд цахим орчинд байршуулж, цаг хугацаа орон зайн хамааралгүйгээр мэдээлэл авах боломжийг иргэдэд бүрдүүлэв.

7.Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолын дагуу заагдсан хугацаанд 15 сумын болон аймгийн хөгжлийн индексийг 2020 оны жилийн эцсийн байдлаар тооцохоор ажиллаж байгаа бөгөөд одоогоор холбогдох байгууллага, сумдаас шаардлагатай мэдээллийг гаргуулах, ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ, зөв эсэхийг нягтлах ажлууд хийгдэж байна. Эдгээрийг хийсний дараагаар тооцож гаргах, цахим системд оруулах ажлууд хийгдэнэ.

8.Коронавирусын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд аймгийн хэмжээнд халдвар хамгааллын шаардлагыг хангасан худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

9. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 дүгээр тогтоолоор айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд төрөөс хариуцан төлж байгаатай холбогдуулан коронавируст халдварын цар тахлын улмаас орон нутагт ажлын байр, талбай, лангуу түрээслэж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон нөхцөлийг харгалзан үзэж, түрээслэгч аж ахуйн нэгж, иргэн, байгууллагаас нөөц боломждоо тулгуурлан түрээсийн төлбөрөө бууруулах, хөнгөлөх, чөлөөлөх арга хэмжээг авч ажиллах саналыг тавин ажиллаж байна.

10. Коронавируст халдварын цар тахлын улмаас эдийн засгийн хохирол багатай даван туулах, орон нутагт ажлын байраа хадгалж үлдэх, үйлдвэрлэл эрхлэгчийг дэмжих хүрээнд аймгийн бүх оёдлын үйлдвэрлэл эрхлэгчдээс хөдөлмөр хамгааллын хувцасыг Оюутолгой ХХК-нд нийлүүлэх хүсэлт саналыг хүргүүлэн ажиллаж байна.

11. Сангийн яаманд Номгон суманд баригдаж ашиглалтад орсон 320 хүүхдийн сургуулийн барилгын үлдэгдэл 1115,0 сая төгрөгийн санхүүжилтийг улсын 2021 оны төсвийн тухай хуульд батлагдсны дагуу гүйцэтгэгчид олгуулах саналыг холбогдох материалын хамт хүргүүлэв.

12. Салбарын чиглэлийн хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тооцн гаргаж ажилласан бөгөөд одоогоор Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцон гаргаж байна.

13. Салбарын чиглэлээр ирүүлсэн нийт 28 албан бичиг, 2 өргөдлийг шийдвэрлэн ажилласан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

1. Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч,

дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 сарын 01-ээс 2021 оны 07 сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төрөөс хариуцахаар баталсантай холбогдуулан БОАЖЯ-аас 01 сарын 07-ны өдөр онлайн хурал зохион байгуулж түр журмын төсөл хэлэлцэв. Тус ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 2019 оны 12 сараас 2020 оны 07 сар хүртэлх хугацааны энгийн хог хаягдлын хураамжийн судалгааг гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020.01.14-ний өдрийн 2-88 тоот албан бичгээр хүргүүлэв.

2. Өмнөговь аймгийг 2021 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлэхээр тусгагдсан 20 арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг гаргаж Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлэв.
3. БОАЖСалбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр 2020 онд гарсан аймгийн Засаг даргын 52 захирамжийн хэрэгжилтийг тооцож и-оффисын программд оруулав.
4. Аймгийн засаг даргын 2020 оны 01 албан даалгавар, 2020 оны хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр ажил сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, ЗГҮАХ-ийн хэрэгжилтийг тус тус гаргаж ХШҮДАХ-т хүргүүлэв

НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР:

1. 1Коронавирусын (Ковид-19) халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шинжилгээ оношилгооны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вируслогийн лабораторийн хэсгийг засварлах, тохижуулах засварлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Ноён сумын сум дундын эмнэлэгт вируслогийн лабораторийн хэсгийг засварлаж, тохижуулан бэлэн байдал хангасан.
2. Ноён, Ханбогд, Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвүүд болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлтгэл бэлэн байдал хангаж, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг халдваргүйжүүлэх, ариутгах үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлж, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангасан.
3. Эрүүл шүд” дэд хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг хуралдуулж, хөтөлбөрийн төсөлд санал авах арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Мөн нийт сумдын Засаг дарга нарт албан бичиг хүргүүлж хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд сум орон нутгийн зүгээс зохион байгуулах арга хэмжээний санал хүлээн авч ажилласан.
4. Шинэ коронавирусын (COVID-19) халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах зорилгоор Ноён, Ханбогд сумын сум дундын эмнэлэгт PCR шинжилгээ хийхэд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл болон хувийн хамгаалах хэрэгслийг Эрүүл мэндийн газарт хүлээлгэн өгч, шаардлагатай нөөц бүрдүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгслээр ханган нөөц бүрдүүлж байна.

5. Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдал хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Коронавирусийн болзошгүй эрсдэлтэй холбоотойгоор 2021 оны 1 дүгээр сар 21-ний өдрийн байдлаар 2 иргэнийг тусгаарлан ажиглах байранд, 378 иргэнийг гэрээр тусгаарлан ажиллаж байна. Нийт 385 иргэнийг түргэвчилсэн тестээр шинжилгээнд хамруулж, 405 иргэнийг PCR шинжилгээнд тус тус хамруулахад бүх хариу сөрөг гарсан. Тандалт шинжилгээг нийт хүн амын тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 1.Зорилтот бүлгийн 11 өрхөд Засаг даргын нөөц хөрөнгөөс тус бүр 2тн нүүрсний дэмжлэг үзүүлж гэрт нь хүргэж өгсөн.
- 2.Өмнөговь аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн хүнсний дэмжлэг шаардлагатай өрхүүдийн судалгааг гаргаж нэгтгэсэн.
- 3.Гурвантэс сумын 1 иргэн, Даланзадгад сумын 2 иргэнд иж бүрэн гэр худалдан авах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн.
- 4.Өмнөговь аймгийн 15 сумын ЗДТГ-ын албан хаагчдын хүйсийн нэгдсэн судалгааг гаргасан.
- 5.Ахмадын байгууллагын санхүүжилтийн асуудлыг аймгийн ИТХТ-ийн хурлаар хэлэлцэж “Ахмадын чөлөөт холбоо”-той гэрээ байгуулж ажиллахаар шийдвэрлэсэн.
- 6.Аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг аймгийн ИТХТ-ийн хуралд танилцуулсан.

БОЛОВСРОЛЫН САЛБАР

1. “Говийн ирээдүй хүүхэд”, “Эзэмшсэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая”, “Сурагч солилцоо”, “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар тус тус байгууллаа.
2. “Говийн ирээдүй хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг хуралдуулж, хөтөлбөрийн зорилго чиглэлийг танилцуулж, хөтөлбөрт тусгах саналыг цахимаар хүлээн авлаа. Нийт 4198 хүн санал ирүүлсэн байна. Саналыг нэгтгэж, хөтөлбөрөө боловсруулж байна.
3. НҮБ-ийн Хүн амын сангийн санхүүжилтээр Даланзадгад сумын 3,4 дүгээр сургуульд үе тэнгийн дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Банхар” төслийг хэрэгжүүлж эхлүүлээ. Тус төслөөр 80 хүүхэд, 40 багш, 40 эцэг эхийг сургагч багшаар бэлтгэж, сургуулиудад мэргэжлийн сэтгэл зүйчийг ажиллуулах юм.
4. Англи хэлний уншлагын марафон төслийг 12 дугаар ангийн 320 сурагч, англи хэлний 30 багшийг хамруулан 6 сарын хугацаатай хэрэгжүүлэхээр эхлүүлээ. Уг төслийг хэрэгжүүлэх зардалд орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Уг төслийг “Лингорс” компанитай хамтран хэрэгжүүлнэ. Энэ

нь хэрэглэхэд хялбар систем дээр суурилсан хялбаршуулсан унших бичгийн нэгдсэн онлайн номын сан юм.

СОЁЛ СПОРТЫН САЛБАР

1. Өмнөговийн домогт хүмүүс, хууч яриа, хүчит бөх, хурдан морь, сур харваа, шагайн харвааны тухай “Өмнийн говийн хийморь” сонсдог ном”-ын нээлтийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

1. Аймаг, сумдын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2020 оны 12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрийбаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган баталгаажуулж, Сангийн яамны Төрийн сангийн газарт татууллаа.
2. Аймгийн төрийн сангийн харъяа нийт 43 төсөвт байгууллагын 2020 оны 12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан.
3. Орон нутгийн төсвийн орлогын 2020 оны 12-р сарын мэдээг аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлж, баталгаажуулсан.
4. Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2020 оны 12 сарын өр авлагын мэдээг хүлээн авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
5. “Төсөв санхүүгийн өнөөгийн байдал” мэдээллийн эмхэтгэлийг 2020 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн хэвлэж, мэдээллийн самбар, E-оффис болон аймгийн вэб сайтад мэдээлсэн болно.
6. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 2021 оны төсвийг сум байгууллагуудаас авч нэгтгэж төсвийн төлөвлөлтийн Пискал программд шивж оруулан сангийн яаманд илгээж 2021 оны жилийн төсвийг татуулах гэж байна.
7. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд өдөр тутам хяналт тавьж ажиллалаа.
8. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.
9. ОНТХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн 12 сарын мэдээг гаргаж шилэн дансанд байршуулсан.
10. ОНТХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн жилийн судалгааг гаргаж орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.
11. ААНБ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан И-баланс програмд шалгаж баталгаажуулалтыг хийж эхэлж байна.
12. 2020 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан гаргаж буйтай холбогдуулан холбогдох өглөг авлагын тооцоог гаргасан.
13. 2020 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланг гаргаж аудитын байгууллагаар шалгуулахад бэлтгэж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР

№	Хийж, гүйцэтгэх ажил	Хэрэгжилт	Хариуцах эзэн
1	Хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдийн ажлыг /гарган ирүүлж байгаа тайлан мэдээний/ чанар үр дүнгээр үнэлдэг системийг нэвтрүүлж эхлэх	Мэргэжилтнүүдийн гарган ирүүлж байгаа хэрэгжилт, тайлан мэдээний чанар үр дүнг тухайн хэлтсийн дарга хянаж, баталгаажуулсны үндсэн дээр ХШҮДАХ-т ирүүлж хэвших, талаар хэлтсийн дарга нарын шуурхай хурал дээр албан ёсоор танилцуулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлан мэдээний чанар үр дүнг үнэлдэг системийг нэвтрүүлж эхэлхээр үнэлгээний самбар гаргаад байна. Энэхүү ажлыг хэвшүүлж, хийж гүйцэтгэхэд ХШҮДАХ-ээс гадна хэлтсийн дарга нарын оролцоо хамгийн чухал байна.	Б.Уянга (Хэлтсийн дарга) Хэлтсийн мэргэжилтнүүд <u>Хэрэгжилт: 100%</u>
2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг хэлтсүүдээс авч нэгтгэх, боловсруулах	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 76 шалгуур үзүүлэлтийг нэгтгэн, боловсруулсан. Шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа бодлогын 1 зорилтод тухайн зорилтын үр дүнг шууд илэрхийлэх 1-ээс дээш тооны шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, 2020 оны үзүүлэлтийг суурь түвшин болгон авч, 4 жилийн хүрэх түвшинг тооцсон. Мөн 2021 оны үндсэн чиглэл, Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлттэй уялдуулсан.	О.Отгонтунгалаг (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
3	УИХ, ЗГ-ын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн ХШҮ-ний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх	2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /new.unelgee.gov.mn/-д байршуулсан 99 шийдвэрийн 197 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 97.7 хувиар үнэлэв. Хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, ЗГХЭГ-т цахимаар болон цаасаар хүргүүлээд байна.	М.Номиндарь (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
4	ЗГ-ын ажиллагааны хөтөлбөрийн заалтуудыг эзэнжүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /new.unelgee.gov.mn/-д орсон ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 18 заалтыг эзэнжүүлэн холбогдох хэлтэс, мэргэжилтний хяналтад өгсөн бөгөөд дээрх заалтуудын хэрэгжилтэд ХШҮ хийгж байна.	М.Номиндарь (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
5	Төсвийн шууд захирагчийн 2020	Аймгийн Засаг даргын дэргэдэх 21 агентлаг, 3 төсөвт байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн	М.Номиндарь (Мэргэжилтэн)

	оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийж дуусгах	төлөвлөгөөний хэрэгжилтэд ХШҮ хийж байна.	<u>Хэрэгжилт: 50%</u>
6	Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлтэс, мэргэжилтнүүдээс авч дуусгах	Хэрэглэгчийн үнэлгээний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө нь 48 заалт арга хэмжээтэй байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж ирүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгөн хэлтэс, мэргэжилтнүүдээс дээрх төлөвлөгөөний хэрэгжилтийг авч нэгтгэв.	Г.Цэнгэлмаа (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
7	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийг хэлтэс, мэргэжилтнүүдээс авч дуусгах	Аймгийн Засаг даргын 4 албан даалгаврын 140 заалтын хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар хэлтэс, мэргэжилтнүүдээс авч нэгтгэн ХШҮ хийв. Аймгийн Засаг даргын 574 захирамжийн хэрэгжилтийг хэлтэс, мэргэжилтнүүдээс авч нэгтгэж, ХШҮ хийв.	Г.Цэнгэлмаа (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
8	Хэлтсийн самбаруудыг шинэчлэх талаарх саналуудыг нэгтгэж, схем гаргах	ХШҮДАХ-ийн 2021 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөний самбар, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг үнэлэх үнэлгээний самбар, аймгийн ЗД-ын дэргэдэх агентлагууд болон сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний самбаруудыг хийж байршуулсан.	М.Номиндарь (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>
9	Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд ХШҮ хийх	Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд нийгмийн бодлого, эдийн засгийн бодлого, төрийн захиргаа, эрх зүйн бодлого гэсэн 3 бүлэг, 13 хэсэг бүхий нийт 138 арга хэмжээг тусгаж, аймгийн ИТХурлын 2019 оны 9/3 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэнд ХШҮ хийлээ. Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлд тусгагдсан нийт 138 арга хэмжээнээс “Үр дүнтэй” буюу 90-100 хувийн биелэлттэй 108 арга хэмжээ, “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 60-89 хувийн биелэлттэй 20 арга хэмжээ, “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 31-59 хувийн биелэлттэй 4 арга хэмжээ, “Үр дүнгүй” буюу 0-30 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 4 арга хэмжээ байгаа бөгөөд бодлогын баримт бичгийг 92.2 хувь буюу “Дүүрэн хангалттай” хэрэгжүүлж ажилласан байна.	О.Отгонтунгалаг (Мэргэжилтэн) <u>Хэрэгжилт: 100%</u>

10	Байгууллага болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал оруулах, нэгж, болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах,	Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээний саналуудыг нэгтгэж ТЗУХ-т хүргүүлэв. Мөн 2021 оны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулав.	Б.Уянга (Хэлтсийн дарга) <u>Хэрэгжилт: 100%</u>
----	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------

ЦЭРГИЙН ШТАБ:

Нэг. Дайчилгааны бэлэн байдлын талаар:

“Цайдам” дохионы хадгалалт хамгаалалтыг 05, 26-ны өдөр Цэргийн штабын дарга хурандаа Ж.Амаржаргал шалгаж, шалгасан тухай тэмдэглэл хөтөлсөн. Илэрсэн зөрчилгүй, дохио хэвийн хадгалагдаж байна.

Сумдын бэлэн байдлыг хангах төлөвлөгөөний дагуу 2020 онд хэрэглэгдсэн дадлагын дохиог хураан авч, 2021 онд хэрэглэгдэх дадлагын дохиог сумд руу хүргүүлсэн.

ЗХЖШ-аас ирүүлсэн шинэ “Дайчилгааны заавар”, “Дайчилгааны даалгавар, удирдамж”-уудыг хуучин дайчилгааны төлөвлөгөөний даалгавартай харьцуулан судлаж, шинээр хийх Өмнөговь аймгийн “Дайчилгаагаар нөхөн хангах төлөвлөгөө”-нд тусгагдах асуудлуудыг боловсруулан ажиллалаа.

Дайчилгааны нууц баримт бичигтэй танилцах албан тушаалтнуудын жагсаалтыг гаргаж, Цэргийн штабын даргаар батлуулан, жагсаалтанд орсон албн тушаалтнуудаар нууцын баталгааг гаргуулан ажиллалаа.

Хоёр. Цэргийн бүртгэлийн ажлын талаар:

Өмнөговь аймгийн Засаг даргын 2021 оны А/49 тоот захирамж, Цэргийн штабын даргын 2021 оны 05 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2021 оны 01 дүгээр сарын 06-наас 01 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Даланзадгад, Баяндалай, Ханбогд, Цогтцэций сумдуудад, 21-нээс 22-ны өдрүүдэд Булган суманд тус тус цэргийн тоо бүртгэлийн ажлыг хэрхэн явуулж байгаа талаар шалган, туслах үйл ажиллагаа явууллаа. Шалган туслах ажлаар сумын багийн Засаг дарга нарын дунд “Цэргийн бүртгэлийг зохион байгуулах” талаар семинар, сургалтыг зохион байгуулж, цэргийн бүртгэлийг сум, багт хэрхэн зохион байгуулж буй ажлын явцтай танилцан, цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг үнэн, зөв бүртгэж байгааг шалган дүгнэж, гаргасан алдаа, дутагдлыг нь арилгуулж, мэргэжлийн удирдлага, зааварчилгаа, зөвлөмжөөр ханган ажиллалаа.

Гурав. Цэргийн сургалт бэлтгэл, сурталчилгааны ажлын талаар

Цэргийн штабын 2021 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан БХЯ-ны холбогдох албан тушаалтнуудаар хянуулан төрийн нарийн бичгийн даргаар батлуулахаар хүргүүлсэн.

Өмнөговь аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээ батлуулахаар гэрээний төслийг БХЯ-ны СБТГ-т хүргүүлсэн.

Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, аймгийн хэмжээнд Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 100 жил, ардын хувьсгалын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг гарган түүний хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Цэргийн штабын сургалтын материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд таван ханатай гэр болон биеийн тамирын техник хэрэгслүүд өнгөт принтер, зураг авдаг дрон, люминатрын машин, цэргийн дүрэмт хувцас зэргийг худалдан авах ажлыг хэрэгжүүлсэн.

Ковид-19 цар тахлын үед Өмнөговь аймгаас хугацаат цэргийн алба хааж буй, амжиргааны түвшин доогуур амьдралтай 17 хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт нүүрсний болон хүнсний хэрэглээний бүтээгдэхүүний дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

Дөрөв. Бусад ажлын талаар

Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 100 жил, Батлан хамгаалах яамны 110 жилийн ойг тохиолдуулан батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, сурталчилах ажлыг биечлэн хэрэгжүүлж иргэд залууст цэрэг эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд санаачлагатай ажиллаж буй зарим алба хаагч, иргэдийг шагнуулахаар нэрсийг нь байгууллагуудаас авч, тодорхойлолтыг нэг бүрчлэн бичиж, шагнуулах саналыг БХЯ, ЗХЖШ, бусад байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Цэргийн штабын хуучин 2020 оны албан бичиг, баримтыг үдэж архивлан, шинэ 2021 оны ангилал хийн, Цэргийн штабын даргаар батлуулсан.

Ковид-19 цар тахлын үед Өмнөговь аймгийн иргэдийг татан авах комиссын хувьд Улаанбаатар хотод гацсан иргэдийн нэрсийн судалгааг сумдаас авч, иргэдийг ээлж дараатайгаар татан авах ажлыг зохион байгуулсан.

СУМ БАГИЙН МЭДЭЭЛЭЛ

БАЯН-ОВОО

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:

“А” захирамж-9, “А” тушаал-4, “Б” тушаал-2

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Нийгмийн даатгалын байцаагчаар шинээр ажилд орж байгаа И.Содбаяр Өмнөговь аймгийн нийгмийн даатгалын газар дээр 7 хоног дагалдан сургалтанд хамрагдлаа. Газрын даамлын ажилд шинээр орж байгаа А.Мөнхзул аймгийн барилга хот байгуулалтын газар дээр 7 хоног дагалдан суралцлаа. Сумын удирдлагууд, эрүүл мэндийн төвийн эрхлэгч нар аймгийн удирдлагуудтай цахим хуралд оролцлоо.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Баян-Овоо сумын жилийн эцсийн мал тэжээвэр амьтдын тооллогын ажлаа нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй баг 6 чиглэл хэсэгт хуваагдан амжилттай зохион байгуулж 180821 толгой мал сүрэг тоолуулж 11120 толгой малаар сумын мал сүрэг өслөө. Сумын хэмжээнд гарах орох хөдөлгөөнийг хянах 2 шалган нэвтрүүлэх цэгт төрийн албан хаагч нар ээлжлэн жижүүрлэж байна. Сумын нутагт хөрш зэргэлдээ сум аймгаас отроор орж ирж өвөлжиж байгаа айл өрхүүдийн өвөлжилтийн байдалтай танилцаж сумын ИТХ-с гаргасан зөвлөмжийн дагуу хариуцлагын гэрээг байгууллаа. Сумын бага дархан газрын нутаг дэвсгэрт болон Налих багийн Хадах навтгарын уулаар нутагладаг ан амьтадад өвс хучир, мөс тавьж биотехникийн ажил зохион байгууллаа. Сумын нийт малчин өрхүүд болон мал бүхий айл өрхүүддээ 4000 боодол өвс, мөн 2000 шуудай тэжээлийг тараан олголоо. Сумын эрүүл мэндийн төвийн эмч сувилагчаас бүрдсэн 2 хэсэг гашуун сухайт авто замын дагуух үйлчилгээний цэгийн ажилчид болон жолооч нараас түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх ажилд дайчлагдан ээлжээр 2 удаа ажиллалаа. Сумын нутаг дэвсгэр дэхь нүүрс тээврийн авто замын дагуух үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд ариутгалд халдваргүйтгэлийн ажлыг сумын мал эмнэлэгийн тасгийн мэргэжилтэн болон сумын эрүүл мэндийн төвтэй хамтран 2 удаа зохион байгууллаа. Сумын төвийн үйлчилгээ үзүүлэгч салбар нэгжүүдэд сумын ЗДТГ-с томилсон ажлын хэсэг тогтмол хяналт хийж байна. Жилийн эцсээр татвар дутуу төлөгдсөн байгууллага аж ахуйн нэгжүүдээс татвараа нэмж төвлөрүүлэх ажлын зохион байгууллага. Сумын бага дархан газар болон ан амьтан үхсэн дуудлагын дагуу 2 удаа хяналт хийж хээрийн дуудлаганд ажилласан. Ан амьтад зориулсан биотехнологийн ажлыг 2 хэсэгт зохион байгуулсан.

БУЛГАН

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Энэ сард сумын ИТХ-аас 2 тогтоол, 3 асуудал хэлэлцсэн. Засаг даргаас А захирамж 13, ЗДТГ газрын даргын А тушаал 5, Б тушаал 1 тус тус гарсан байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сумын Хорио цээрийн дэглэм тогтоосны дагуу 2021.01.12-оос 2021.02.01-нийг хүртэл угтах үйлчилгээний жижүүрийн хуваарийг гарган ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвийн Эмчийн үзлэгт 85 хүнийг хамруулсан. Хүүхдийн А аминдэмийн дархлаажуулалтад 110 хүүхдийг хамруулаад байна. Нийт 5 жирэмсэн эхийг хянаж байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ

Өмнөговь аймгийн Булган сумын нийт малчин өрхийн 80 гаруй хувь нь Цогт-Цэций, Хүрмэн, Баян-Овоо, Ханбогд, Номгон, Манлай-н нутгаар Отор нүүдэл хийж байгаа бөгөөд эхний ээлжид Цогт-Цэций суманд суугаа малчдад 1000 боодол өвс, Номгон суманд байгаа малчин өрхүүдэд 1000 боодол өвс 10 тонн тэжээл /Хивэг/ тус тус отроор байгаа хэсэгт ойртуулан хөнгөлөлттэй үнээр тараан малчдад тусламж үзүүлээ. Дараагийн ээлжид бусад суманд байгаа малчин өрхүүдэд тараах бэлтгэл ажлыг төлөвлөөд байна. Булган сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Улаан нуурын Хулсан-д оторлож яваа сумын 10 гаруй өрхөөр малчдын өвөлжилт, сумын өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн асуудлаар ярилцаж ард иргэдтэйгээ уулзалт хийлээ.

ГУРВАНТЭС

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

ЗДТГ: Шивээхүрэн хилийн боомтоор нүүрс тээвэрлэлт явуулж эхэлсэнтэй холбогдуулан нүүрсний 4 уурхай, нүүрс тээврийн 37 ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Шивээхүрэн хилийн боомт болон Морин загийн постонд 2 байгууллагын албан хаагчид 13 ажиллаж байна. Өдөртөө 300, 350 нүүрс тээврийн авто машин хилээр тээвэрлэлт хийж байна.

Сумын Засаг дарга 7 хоног бүрийн 3 өдөр Шивээхүрэн хилийн боомт Морин загийн постонд ажиллаж байна.

Хоёр: Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан ажил:

2021 оны 01 сарын 16 нд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн хуралын дарга Б. Бадраагаар ахлуулсан ажлын хэсэг Гурвантэс сумын Төсөвт байгууллагын дарга нар, Онцгой комиссын гишүүдтэй уулзалт зохион байгуулж цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой санал хүсэлт ажлын талаарх мэдээллийг өгч ажилласан. Мөн уулзалтад Гурвантэс, Ноён, Сэврэй сумын удирдлагууд оролцож уул уурхайтай ямар чиглэлээр хамтын ажиллагааг илүү сайжруулах боломжтой байгаа талаар санал уламжлан хамтран оролцсон. 2020 оны 12 сарын 30-нд Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржоор ахлуулсан ажлын хэсэг цаг үеийн асуудлаар сумын Удирдлагууд, Төсөвт байгууллагын дарга нартай уулзалт зохион байгуулсан. Мөн Шивээ хүрэн боомтод хүрч ажилсан.

Гурав: Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Сумын шуурхай жижүүрийг 24 цагаар гарган ажиллаж мэдээг 12, 20 цагт өгч

байна. 2021 оны 01 сарын 07 нд Сумын нийт нутгийн ихэнх хэсгээр цасан бүрхүүл тогтож 2020-2021 оны өвөлжилт хаваржилт хүндэрч байгаатай холбогдуулан Засаг даргын хүсэлтийн дагуу Жавхлант орд ХХК, Бласт ХХК, Өсөх зоос ХХК-иудаас 36 тонн өвсийг суманд хүлээлгэн өгсөн. Дээрх өвсийг малчид, мал бүхий өрхүүдэд үнэгүй олгосон. 2021 оны 01 сарын 20 нд Монголын Улаан загалмайн нийгэмлэг, Олон улсын Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос зудын нэн өндөр эрсдэлтэй аймаг, сумдын малчдад туслах хөтөлбөрийн хүрээнд малын эрдэс тэжээлийн багцын тусламжийг олгож байгаа бөгөөд Өмнөговь аймгийн Улаан загалмайн хороо, Сумын Улаан загалмайн анхан шатны хороо хамтран сумын 30 өрхөд энэ багцыг хүргэж ажиллалаа.

- 2021 оны 01 сарын 19-20-ны өдрүүдэд сумын төвийн иргэд албан байгууллагууд бүх нийтийн хог цэвэрлэгээг хийсэн
- 2021.01.17 нд Сумын засаг даргын хүсэлтийг уул уурхайн компанууд хүлээн авч малчдад өвс тэжээлийн тусламж үзүүлэх ажлыг шийдвэрлэсээр байна. 2021 оны 01 сарын 18 -нд гоёот багт Баатарван компаны хандивын 20 тонн тэжээл, 2021 оны 01 сарын 19-нд Баясах багт Өсөх зоос компаны хандивын 20 тонн тэжээл, 2021 оны 01 сарын 20 Тост багт Саус говь сэндс компаны хандивын 10 тонн тэжээл, 2 тонн өвсний дэмжлэг үзүүллээ.
- 2021 он ы01 сарын 06 нд шалгарсан байгууллага болон идэвхтэй оролцсон байгууллагуудад талархал батламж гардууллаа "Өрхийн хөгжлийг дэмжих жил-2020" хүрээнд 30 өрх сонгогдон, тэдний амьдрах орчин, өрхийн хөгжилд нь чиглэсэн үйл ажиллагааг сум орон нутгийн удирдлагууд, аж ахуй нэгж төрийн байгууллагууд, орон нутгийн өмчит компаниудтай хамтран зохион байгуулсан билээ.
- Сумын Засаг дарга Уул уурхай комдануудад санал тавьсаныг хүлээн авч
 - ✓ Өсөх зоос ХХК 6 ажлын байранд 2021 оны 01-р сарын 07-ны өдрийн 10 цагаас бүртгүүлсэн иргэдээс ярилцлага авч нийт 11 иргэнийг ажлын байраар хангасан.
 - ✓ МАК ХХК 10 ажлын байранд 2021 оны 01 сарын 09 нд бүртгүүлсэн иргэдээс ярилцлага авч нийт 10 иргэнийг ажлын байраар хангасан.
 - ✓ Бласт ХХК 15 ажлын байранд 2020 оны 12 сарын 21 нд бүртгүүлсэн иргэдээс 15 иргэнийг ажлын байраар хангасан.

ДАЛАНЗАДГАД

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Засаг даргын А захирамж-13, Б захирамж-1, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал-6, Б тушаал-10, 2020 оны 12 сард Даланзадгад сумын

ЗДТГазарт 54 албан бичиг хүлээн авсан. Хугацаатай 12, хугацаа болоогүй 6, шийдвэрлэсэн-6. Ирсэн санал, өргөдөл гомдол 8, шийдвэрлэж хаасан 2, Хугацаандаа яваа 6 санал өргөдөл байна. Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1 дүгээр хурал 2021 оны 01-р сарын 08-ны өдөр хуралдаж 3 асуудлыг хэлэлцлээ.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2021.01.07-нд Сумын Засаг дарга харьяа сургууль, цэцэрлэгүүдийнхээ захирал, эрхлэгч нартай Хөдөлмөрийн гэрээ байгуулан, санал бодлыг сонсож 2021 онд боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг танилцуулж цаашид хэрхэн хамтран ажиллах болон хөл хорио тогтоосон энэ цаг үед байгууллагадаа тавих хараа хяналтыг сайжруулах талаар үүрэг чиглэл өглөө.

Улсын Онцгой комиссын Шуурхай штаб, Аймгийн Онцгой комиссоос зохион байгуулсан Гамшгийн цагийн байдал, авах арга хэмжээний талаарх 4 удаагийн онлайн хуралд Цэрэг, онцгой байдал хариуцсан бодлогын мэргэжилтэн оролцсон.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

2020.12.25-нд Коронавирус /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Шим билэг, Өнө-Орших, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээнд түр хугацаанд өөрчлөлт оруулж иргэдэд үйлчлэх асуудал дээр эмч нартай зөвлөлдөн шийдвэр гаргаж, эрсдэлтэй бүсээс ирсэн иргэдийн гэрийн ажиглалт тусгаарлалтын 14 хоногийн хяналтыг сайжруулах бүртгэлийг хялбарчлах аргаар ашиглаж онлайн бүртгэлийн талаар өрхийн эмнэлгээс багуудад танилцуулж, цаашид хяналтыг сайжруулах талаар Багийн Засаг дарга нар үүрэг чиглэл өглөө.

2020 оны жилийн эцсийн мал тооллогоор сумын хэмжээнд 136382 толгой мал тоологдож, нийт 444 малчин, 182 мал бүхий өрх бүртгэгдсэн байна.

Даланзадгад сумын 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөө 260020.0 мян.төгрөг гүйцэтгэл 2959623.9 мян.төгрөг болж 113.8 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 10000.0 мян.төгрөг, гүйцэтгэл 10510.3 мян.төгрөг 105.1 хувьтай байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ

Даланзадгад сумын Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрээр нөөцийн өвс, тэжээлийн үнэ тогтоох, хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах тухай хэлэлцэн сумын нийт 626 малчин, мал бүхий өрхөд 10 боодол өвсийг 10.000 төгрөгөөр, 444 малчин өрхөд 3 шуудай тэжээлийг 15.000 төгрөгөөр олгохоор шийдвэрлэж, өвс, тэжээл олгох ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 06-16-ны хугацаанд зохион байгуулан ажиллалаа.

Цар тахал КОВИД-19-ын дэгдэлтээс урьдчилан сэргийлж халуун ам бүлээрээ шинэ оноо угтах уриалгыг дэвшүүлж Даланзадгад сумын Засаг даргын

тамгын газраас иргэдийнхээ дунд “БИД НЭГ ГЭР БҮЛ” цахим видео бичлэгийн уралдааныг “Хатан мандал” ХХКомпани хамтран ажиллаж шагналын санг нэмэгдүүлэн зохион байгуулж нийт 9 байрыг шалгаруулж, шилдэг оролцогч 10 хүүхдэд гарын бэлэг гардууллаа.

2020.12.23-нд Сумын удирдлагууд Захирагчийн ажлын албаны нийт ажилтан тус бүрд 50000 төгрөгийн хүнсний талон, 7350 ширхэг маск, витаминьг сэтгэлийн дэм болгон гардуулан өглөө.

Сумын Онцгой комиссоос Өрхийн эрүүл мэндийн төвийн хамт олонд 3000 ширхэг 1 удаагийн маск, 45 ширхэг нүүрний хаалтыг гардуулж өглөө.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

3-р баг: Халдвар хамгааллын дэглэм баримтлуулах зорилгоор зай барих наалт, QR кодийг байршуулсан.

5-р баг: 2020.12.30 АИТХурлын төлөөлөгч Б.Чинбат, СИТХурлын төлөөлөгч П.Сүхээ хамтран “Бидний шинэ жил” бүтээлийн уралдаан зарлаж, оролцогч болон зорилтот бүлгийн 56 хүүхдэд гарын бэлэг гардуулсан.

7-р баг: "Малчдаа дэмжье" аяны хүрээнд Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга Багийн 20 малчин өрх тус бүрд 30.000 төгрөгийн үнэ бүхий эмийн санг нэн шаардлагатай эм, эмийн хэрэглэлийн /заавартай/ хамт гардуулан өглөө.

СЭВРЭЙ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргын А Б захирамж 15 гаргасан . Үүнд /Ажлын хэсэг байгуулах тухай -10, Хүүхэд үрчлэн авах тухай -1, Цалин шинэчлэн батлах тухай-1, Сарчилсан хуваарь батлах тухай-1, Тусгаарлан ажиглах байранд ажиллах албан хаагчдын ажлын чиг үүрэг, ажиллах бүрэлдэхүүн хуваарийг батлах тухай-1, Ажилд түр томилох тухай- 1, Тамгын даргын А Б 2 тушаал боловсруулан гарсан. Орон тоо, цалин шинэчлэн батлах тухай-1 Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг өөрчилсөн тухай -1

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдсан, Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Сайн төрийн албан хаагч”, Сайн багш-Оюунлаг сурагч”, “Ядууралгүй Сэврэй” “Ахмадын сургаал Алтнаас үнэтэй”, “Зөв бүхэн зөвхөн манай гэр бүлээс” дэд хөтөлбөрүүдийг баталсан. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 2021 оныг “Ахмад буурлаас суралцаж, зөв бүхнийг гэр бүлд төлөвшүүлэн, сайн багш оюунлаг сурагчийг дэмжих жил” болгон зарласан. 1 дүгээр сарын 9-ны өдөр ИТХ-ын дарга Б.Бадраа, Аймгийн Засаг даргын орлогч Н.Энхбат нар Төрийн албан хаагчидтай уулзаж цаг мэдээлэл хүргэж ажилсан. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хуралдаж Ахмад настны тухай хуулийн 5.1.2-т даасны дагуу 2 ахмад настны бичиг баримтыг

хурлаар хэлэлцэн дээд газарт хүргэн хянуулан үйлчилгээнд хамруулан ажилласан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Сумын соёлын төвийн хамт олон “Малчдадаа тусъя” хандивын Live тоглолтыг 12/30нд зохион байгуулан хандиваар цугласан 1410000 төгрөгийг сумын онцгой комисстоо өглөө. Засаг даргын Тамгын газрын ХАА тасгийн дарга, багийн Засаг дарга, Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн нар 1 дүгээр сарын 18-19-ны өдрүүдэд сумын нутагт дэвсгэрт оторлож байгаа Баянхонгор, Өвөрхангай аймгийн айл өрхүүдээр явж цаг үеийн мэдээлэл хийж төрийн анхан шатны үйлчилгээг хүргэж ажиллаа. Сумын цагдаагийн хэсэг, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар хамтран сумын нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. 2020 оны зун намартаа ургамлын гарц тааруу байсны улмаас өвөлжилт хүнд өнөөдрийн байдлаар сумын нийт **143** өрхийн **73,2** мянган мал **469** хүн өөрийн аймгийн **11** сумын нутагт оторлож байна. **2020** оны эцэст нийт **162970** толгой мал тоолуулсан.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан Шинэлэг ажил, гарсан үр дүн:

Сумын нийт нутгаар цасан бүрхүүл тогтож зудын байдал бий болсон тул өвс тэжээл шаардлагатай. Цас тахал бүх нийт бэлэн байдал зарлагдсан үед сумын Цагдаагийн хэсэг автомашингүй, Эрүүл мэндийн төвийн авто машин хуучирч муудсан дуудлагад явахад хүндрэлтэй.

Коронавируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээ

Аймаг сум хооронд явах төв зам дээр 24 цагийн пост гарган ажиллаж байна. Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх халдвар хамгаалалын дэглэмийг сайжруулах иргэдэд мэдээ мэдээлэлийг цахимаар болон масс мессежээр хүргэж байна. Тусгаарлалтанд нийт 71 хүн ирсэнээс одоогийн байдлаар 1 хүн тусгаарлалтанд байна. Худалдаа үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэд амны хаалт зүүж хүн хоорондын зай барих, өдөр тутмын цэвэрлэгээ, 2 цаг тутмын агааржуулалт хийх, үйлчлүүлэгч хоорондын зай барих зэрэг мэдээлэлийг өгөхөөр өдөр бүр 10-20 цагийн хооронд хариуцлагатай жижүүр эргүүл гарган ажиллаж байна. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021,01,05 өдрийн 16/03/033/01 дугаар бүхий зөвлөмж болон ухуулга хуудсыг гарган үйлчилгээний 16 байгууллагад тусгайлан зөвлөгөөг өгч ажилласан. Сумын Засаг даргын захирамжийн дагуу тусгаарлан ажиглах байранд ажиллах иргэдийн нэрсийг гарган танилцуулан гарын үсэг зуруулсан. Тусгаарлах байрыг Сургуулийн дотуур байр, зочид буудал, Соёл спортын төвийг тусгаарлах байраар бэлтгэсэн бөгөөд 130 ор дэлгэхээр төлөвлөсөн. Цэцэрлэгийг ногоон бүс 2 дахь эмнэлэг болгон ашиглахаар төлөвлөсөн. Эмнэлэгийн аюултай хог хаягдалын цэгийг шинээр байгуулж хайсжуулан тэмдэг тэмдэглэгээжүүлсэн. Эмнэлэг болон тусгаарлах байрнуудын ковидын бэлэн байдлын видео бичлэг тайланг мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн. 1 дүгээр сард эмнэлэгийн ковидын бэлэн байдлын

нөөцийн бүрдүүлэлтэнд аймгийн Засаг даргаас 3,7 сая, сумын засаг даргаас 3,0 сая төгрөг, эмнэлэгийн төсвөөс 0,8 сая төгрөгний эмнэлэгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодисын хангалтыг нэмэгдүүлэн ажилласан. Ковидын бэлэн байдлын эм тарианы хангалт 87,6%, Ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц 86% Хамгаалах хэрэгсэлийн нөөц 41,3% тай байна.

МАНДАЛ-ОВОО

Нэг .Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

- 1.Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 0.
- 2.Сумын Засаг даргын захирамж 16
- 3.Тамгын газрын даргын тушаал 7

Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

1.Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай цахим хурал 2 удаа, байгууллагын дарга эрхлэгч нарын хурлыг 1 удаа, Онцгой комиссын хурлыг 3 удаа тус тус зохион байгуулав.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

-Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын гэрээг байгуулж татан авалтыг 5 удаа зохион байгуулав

-Цэргийн шинэчилсэн бүртгэлийн ажил 80 хувьтай зохион байгуулагдаж байна.

-Коронавирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээний хүрээнд сумаас гарах, орох тээврийн хэрэгсэл, зорчигчдын хөдөлгөөнд хязгаарлалт хийх пост 1-ийг нэмж гаргав. Хяналтыг 2 постод нийт 40 төрийн албан хаагч томилогдон 24 цагаар үүрэг гүйцэтгэж байна.

-Шуурхай штаб, эргүүл хяналтын постын ажлын хариуцлага, бүртгэлийг сайжруулах үүрэг чиглэлийг холбогдох албан хаагчдад өгөв. Хариуцлагатай пост группийг нээж шуурхай штаб, хяналтын постуудад ажиллаж байга албан хаагчдыг нэгдсэн мэдээ мэдээллээр хангаж, мэдээлэл солилцож байна.

-Аймгийн Засаг даргын 2018 оны А/1160 дугаар захирамжийн дагуу мэдээ тайлангуудыг хугацаанд нь хүргүүлэв.

-Говийн оюу ХДС-н хөрөнгөөр хэрэгжсэн 7 ажлын зургийг тус санд хүргүүлэв

-ХАСХОМ мэдүүлэх тухай мэдээлэл зөвлөмжийг холбогдох 8 албан тушаалтанд хүргэж, мэдүүлэг 80 хувьтай явж байна.

-Сумын шилдэг 9-н албан хаагчдыг тодруулан, шагнал олгов.

-Сумын хэмжээнд өвс тэжээлийн нөөцийг малчдад хямралтай үнээр олгох ажлыг зохион байгуулж одоогоор 20 сая төгрөгний хөнгөлөлт үзүүлээд байна.

Дөрөв. Багт хийгдсэн ажлууд

Сумын хэмжээнд өвс тэжээлийн нөөц бэлтгэх, малчдад хямралтай үнээр хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

1. Гадны аймгийн нутагт оторлож байгаа малчдад өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх
2. Алслагдсан говь, говийн бага дархан цаазат газар өвөлжиж байгаа малчдад дэмжлэг үзүүлэх
3. Өөрийн аймгийн сумдад оторлож байгаа малчдад, өвс тэжээлийг хөнгөлөлттэй үнээр хүргэх
4. Аймгаас олгосон хөнгөлөлттэй өвс тэжээлийг малчдад хүргэх
5. Сумандаа өвөлжиж байгаа малчдад өвс тэжээлийг хөнгөлөлттэй үнээр олгох зэрэг ажлуудыг зохион байгуулж, аймгаас сумдад дэмжлэг үзүүлсэн 55 сая төгрөгийн өвс тэжээлийг 5 удаагийн татан авалт хийн эргэлтэнд оруулан малчдад хүргэж байна. Мөн гадны аймаг сум, өөрийн аймгийн алслагдсан хилийн бүсийн орчмын малчидтай нэг бүрчлэн холбогдож цаг үеийн мэдээлэл өгөн, өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

"Малчдаа дэмжье" аяныг сумын МЗХ-ны санаачлагаар эхлүүлэн 1 сарын 18-аас 3 сарын 18-н хүртэл хоёр сарын хугацаанд үргэлжлүүлэхээр хамтран ажиллаж эхлээд байна.

МАНЛАЙ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

ИТХ-ын хурлын даргын тогтоол- 5, Засаг даргын захирамж Б-1 , Захирамж А-3 , Тамгын газрын даргын тушаал А-2 гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

ИТХ-ын тэргүүлэгчид 2 удаа хуралдаж 3 асуудал хэлэлцсэн. Үүнд. Иргэдийг шагналд тодорхойлох тухай, ГХУСАЗСЗөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай, ИТХТэргүүлэгчдийн хурлын хуваарь батлах тухай. Алтан гадас одонд-12, Хөдөлмөрийн хүндэт медальд-19, Боловсролын тэргүүний ажилтан-8, яамны шагналд-3 иргэнийг тодорхойлон хүргүүлсэн. Пүрэв гараг бүр ЗДТГазрын албан хаагчид дотоод хурал хийж цаг үеийн мэдээлэл болон мэргэжилтэн тус бүр мэдээлэл солилцдог тогтмол өдөр товлоод 4 удаа хурал хийж мэдээлэл солилцсон байна. Сумын Засаг даргын зөвлөл хуралдаж "Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам"ын дагуу 4 багаас 4 малчны материал, " Улсын аварга малчин өрх" –д 1 малчны материалыг хэлэлцүүлэн аймгийн хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. 2021.01.10-2021.01.17 хооронд Өмнөговь аймаг ГХБХБГ-т Сумын газрын даамал ажлын байранд бэлтгэх, ажлын чиг баримжаа олгох сургалтад хамрагдсан. Бага ангийн 9 багш байгалийн ухааны онлайн сургалтад, дунд ангийн 11 багш мэргэжлийн онлайн сургалтад, нийт 20 багш, 3

удирдлага, 2 ажилтан ажлын байрны сургалтад сууж мэдлэг боловсролоо дээшлүүллээ. 2021.01.14, 15нд БСУГ-аас зохион байгуулсан Теле хичээл үзэж байгаа болон үзэж чадахгүй байгаа хүүхдүүдтэй хэрхэн ажиллаж талаар санал бодлоо хуваалцах багш нарын онлайн хуралд 6 багш хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Сумын хэмжээнд мал тооллогын ажил зохион байгуулагдаж 220619 мал тоологдсон. Үүнээс тэмээ-15977, адуу-14434, үхэр-2674, хонь-74204, Ямаа-113330. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээр Сумын хэмжээнд 1 пост ажиллаж төрийн албан хаагчид хуваарийн дагуу посны үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. 2020-2021 оны хичээлийн жилд зохион байгуулагдах Эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлэх “Танхимын ба цахим хичээл асуудал шийдэл” сэдвийн дор баг нар илтгэл бичиж байна. Шинэ коронавирусын болзошгүй тохиолдлын бэлэн байдлыг хангах зорилгоор тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. ӨМА-ын Ханбогд сумын Цагаан хад багт очиж 4 хоногийн хугацаанд урт болон богинын тээврийн жолооч нарт коронавируст халдварын шинжилгээ хийсэн.

Дөрөв. Багт зохион байгуулагдсан ажлууд

Сумын нийт багийн 98 хүүхдийг гэрээр эргэж, 28 жирэмсэн эмэгтэйн хяналтын үзлэгийг гэрийн эргэлтээр хийж байна. 4 багийн мал тооллогын ажил зохион байгуулагдаж Өехий баг-64799, Өгөөмөр баг-63355, Жаргалант баг-57019, Далай баг-35446 тус тус тоолуулса

НОМГОН

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн

Засаг даргын А захирамж-5, ЗДТГ-н даргын А-3, Б тушаал 1, тус тус гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

ЗДТГ-ын хэмжээнд нийт 3 удаагийн хурал зөвлөгөөн, төсөвт байгууллагуудын хэмжээнд 1 удаа хурал зөвлөгөөн зохион байгуулагдсан.

Гурав. Бусад

Аймаг, нийслэлийн захирамжын дагуу сумын Онцгой комисс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран /ковид 19/ халдварт өвчнөөс сэргийлэх заавар, зөвлөмжийг хөдөлгөөнт эргүүл, ЗДТГазрын цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлж байна.

ХАНБОГД

1.ИТХурлын тогтоол, Засаг даргын захирамж, албан тоот

Сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын тогтоол-0, Иргэдийн Тэргүүлэгчдын Хурлын тогтоол 8, явсан бичиг 3, ИТХурлын нарийн бичгийн даргын тушаал 3, ИТХ-д ирсэн бичиг 0, Сумын Засаг даргын захирамж-11, тушаал 3, явсан бичиг 41, ирсэн бичиг 51, өргөдөл 8 бүртгэгдсэн байна.

2.Хурал зөвлөгөөн, сургалт семинар:

Сумын Засаг дарга Х.Нэхийт, Засаг даргын орлогч Х.Отгонжаргал нар 2021 оны 01 дугаар сарын 04-ны өдөр ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж ажил үүрэгтэй нь танилцаж цаашид ямар ажил хийхийг төлөвлөж байгаа болон ажиллах боломж ямар байгаа тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо солилцлоо. Мөн Сумын ИТХурлын дарга Т.Буян-Өлзий, Сумын Засаг дарга Х.Нэхийт, Засаг даргын орлогч Х.Отгонжаргал нар төсөвт болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж цаашид авах хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

3.Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ.

Ковид 19 цар тахалын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан шуурхай штабт өдөр бүр албан байгууллагын дарга эрхлэгч нар жижүүрийн үүргийг гүйцэтгэж иргэдэд мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Шуурхай штаб нь орсон гарсан хүн амын хөдөлгөөн тоон мэдээлэл, маскны нөөц, эмнэлгийн үзлэг, хэвтэн эмчлүүлэгчийн тоо, алс, ойрын дуудлага зэрэг мэдээ мэдээллийг өдөрт 2 удаа Аймгийн шуурхай штабт мэдээллэн ажиллаж байна. Сумын хэмжээнд Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2 постыг 24 цагаар ажиллуулж байна. Коронавирусын өвчний талаар тухайн цаг үеийн мэдээ мэдээлэл, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааг өдөр бүр иргэдэд хүргэн ажиллаж байна.

Сумын эрүүл мэндийн төв нь Цагаан хадны нүүрсний бүх кэмпүүдийг тойрон урьдчилан сэргийлэх үзлэг, хоол хүнсний зөвлөгөө, болон цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан коронавирүсээс урьдчилан сэргийлэх гарын авлага тараах материалуудыг иргэд болон аж ахуй нэгж, албан байгууллага, кэмпүүдэд өгч зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллалаа.

4.Багт хийсэн ажил

Хайрхан багийн Цагаан хад, Гашуунсухайт боомтод ЗӨСҮТ, Аймгийн ЭМГ, ЗӨСТ, Цогтцэций СДЭ, Булган СЭМТ, Баян-Овоо СЭМТ, Ханбогд СДЭ, Хайрхан багийн эмнэлэг, Уул уурхайн компанийн эмч нар болон нийт 24 эмч, мэргэжилтнүүдийн баг хамтран тээврийн жолооч, үйлчилгээний ажилчдыг PCR шинжилгээнд 20000 хүнийг хамруулж шинжилгээг хийж шинжилгээний хариу бүгд

сөрөг гарсан. Ханбогд сумын СДЭ-ээс 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр 10 хоногоор ээлж солин ажиллаж байна.

ХАНХОНГОР

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал 1 удаа болж сумын хэмжээнд ажиллах зөвлөлүүдийг шинэчлэн байгуулсан. Сумын засаг даргын 4 захирамж, ЗДТГ-ын даргын 1 тушаал гарсан. Соёлын төвийн цалингийн сан баталсан. ЕБДСургууль дотоод журам, албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад журмыг шинэчлэн батлан хэрэгжүүлж эхэлсэн.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Өмнөговь аймгийн Засаг даргын цахим хуралд он гарсанаас хойш 4 удаа хуралдаж мэдээлэл авсан. Сумын онцгой комисс 2 удаа хуралдаж иргэдэд цар тахалтай холбоотой зөвлөмж, төлөвлөгөө гарган хүргүүлсэн. Сумын ЗДТГ-ын дотоод хурлыг 3 удаа зохион байгуулж ЗДТГ мэргэжилтэнгүүддээ ажил үүргээ сайжруулах , идэвхжүүлэх тал дээр үүрэг даалгавар өгсөн. Мөн байгууллага бүр дотооддоо цар тахалтай хамааралтай хурал хийж хорио цээрийн дэглэмийг сахин мөрдөж байна. ЕБДСургуулийн багш нар цахим сургалтад удаа дараалан давхардсан тоогоо 30 гаруй хүн хамрагдсан. Мөн байгууллагууд дотоод цахим хурлуудыг тухай бүрт 1-2 удаа хийсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Өмнөговь аймгийн Засаг даргын болон, Ханхонгор сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хүрээнд байгууллага иргэдэд танилцуулах, санал авах зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Цар тахалтай холбоотой улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын албан даалгавар, чиглэлүүдийн хүрээнд сумын төвийн үйлчилгээний байгууллагуудад зөвлөмж хүргүүлж иргэдийн бүртгэлийг тухай бүрт хийлгэж байна. Байгууллагуудын ерөнхий менежерүүдийн болон ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж дүгнэсэн. Сумын цэргийн насны иргэдийн бүртгэлийг хийж, шинэчилсэн судалгааг авч байна. Мал эмнэлэгийн гарал үүсийн гэрчилгээг нийт 37 удаа бичиж, 13,7 тн мах , 10148 ш малын арьс тээврлэгдсэн, мал эмнэлэгийн 4 дуудлагаар 110 толгой малд мал эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Сумын хүүхдийн хамтарсан багийн хурлыг 1 удаа хийсэн, сумын 45 өрхөд аймгийн Засаг даргын захирамжаар хүнсний дэмжлэг хүргэсэн. Хөдөө аж ахуйн салбарт Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд шинээр гаргах, засварлах худгийн захиалгыг гарган хүргүүлсэн, малчдын судалгааг гаргах,

багуудад өвс тэжээлийн хөнгөлөлттэй болон үнэгүй олгогдох өвс тэжээлийн тооцоог гарган хуваарилсан. Сумын хэмжээнд түргэн туламжийн алсын дуудлага 7 удаа, ойрын дуудлага 19 удаа бүртгэгдсэн, дархлаажуулалтын вакцин 3 хүүхдэд, саагийн дархлаажуулалтын вакцинд 29 хүүхдийг тус тус хамруулсан, нялх хүүхдүүд, ахмад настнууд болон бусад байдлаар 95 удаа гэрийн эргэлт хийж 152 удаа амбулаторын үзлэг хийгдсэн. Сумын төсөвт төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд шеф багийнхаа малчдад хүн хүчний болон бусад талын дэмжлэг туслалцааг үзүүлсээр байгаа ба он гараад нийтдээ 10 орчим айлд тусламж хүрээд байна.

Дөрөв.Тухайн сард зохион байгуулсан “Шинэлэг ажил”

Цар тахалтай холбоотой болон цагийн байдал өвөлжилтийн хүндрэлийн байдалтай хамаатайгаар малчдад туслах аяныг сумын залуучууд санаачлан эхлүүлж 4 багийн 40 өрхөд 400 боодол өвс, 40 уут тэжээл олгох ажлыг гүйцэтгэсэн ба мөн зэрлэг ан амьтдад 2 удаагийн оролдлогоор 70 орчим боодол өвсийг тавин өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан . Сумын төвийн золбин нохой устгалыг зохион байгуулсан .

Тав. Багт хийгдсэн ажил

Багийн төвүүдэд өвс тэжээл татан авах ажлыг зохион байгуулсаар байгаа ба сумын зүгээс гэрээ байгуулан авч буй өвс, мөн аймгийн ХАА-н газраас хөнгөлөлттэй үнээр нийлүүлсэн тэжээлүүдийг тус тус багийн төвд байршуулан малчдад хүргэн ажиллаж байна. Отроор Явсан айлуудын судалгааг тухай бүрт гаргаж Засгийн газраас өгөх үнэгүй тэжээл, сумын хэмжээнд нөөцлөн бэлтгэж буй өвсийг хүргэхээр төлөвлөн ажиллаж байна.